



БАЯН - ӨЛГИЙ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сар 16 өдөр

Дугаар А/16

Өлгий

Нэгдсэн эмнэлгийн 2022-2025 оны
стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12-р сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоол, Эрүүл Мэндийн Сайдын 2022 оны 12-р сарын 15-ны өдрийн А/609 дугаар "Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай" тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нэгдсэн эмнэлгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
2. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг Нэгдсэн эмнэлгийн бүх албад, тасаг нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллаж хэрэгжүүлэхийг бүх албадын дарга, тасаг нэгжийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.
3. "Нэгдсэн эмнэлгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйгээр хангаж, жил бүр хяналт үнэлгээ хийж, үр дүнг тооцон ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын дарга /Д.Гүлжан/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дарга /А.Данабек/-д даалгасугай.


ДАРГА

Х.МАНЧУК





Нэгдсэн эмнэлгийн
2023 оны 1 дугаар сарын 6-ны
өдрийн 1/16 дугаар тушаалын хавсралт



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

Төлөвлөгөөг баталсан:
Нэгдсэн эмнэлгийн дарга
/албан тушаал/



Х.Манчук
.....
/огноо/

Төлөвлөгөөг боловсруулсан:
Эрүүл мэндийн тусламж
үйлчилгээ, чанар аюулгүй
байдлын дарга
/албан тушаал/

.....
/гарын үсэг/

Д.Гүлжан
.....
/огноо/

2023 он
Баян-Өлгий аймаг

Баян-Өлгий аймаг

Нэгдсэн эмнэлгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний бүтэц, агуулга

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл.....

Бүлэг 2. Мандатын шинжилгээ.....

Бүлэг 3. Алсын хараа

Бүлэг 4. Эрхэм зорилго.....

Бүлэг 5. Орчны шинжилгээ.....

Бүлэг 6. Стратегийн зорилго.....

Бүлэг 7. Стратегийн зорилго ба тасаг нэгжийн
бүтцийн уялдаа, зураглал.....

Бүлэг 8. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь
болон зорилтот түвшин, стратеги.....

Бүлэг 9. Хавсралт

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Товч танилцуулга

Баян-Өлгий аймаг нь 109583 хүн амтай, 24,6 мянган өрхтэй. Аймгийн төв болох Өлгий суманд 49.1 мянган хүн амьдардаг. 12 сум, 1 тосгон, 90 багтай. Жилийн цэвэр өсөлт 23.4 хувь байна. Хүн амын 36.3 хувийг 15 хүртэлх насны хүүхдүүд, 4.6 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна. Хөдөлмөрийн насны буюу 16-59 насны хүмүүс 59.1 хувийг эзэлдэг. Хүн амын 34.7 хувь буюу 35.1 мянга нь аймгийн төвд, суурин газарт 29.8 хувь буюу 30.2 мянга нь сумын төвд, 35.5 хувь буюу 35.8 мянга нь хөдөө суманд амьдардаг. Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Өлгий сумын нутаг дэвсгэрт анх 1940 онд 15 ортойгоор “Докторын эмнэлэг” нэртэйгээр байгуулагдаж байсан бол 1959 онд 65 ортойгоор “Аймгийн эмнэлэг”, 1967 онд 80 ортойгоор “Нэгдсэн эмнэлэг” гэж нэрлэгдэн үйл ажиллагаагаа явуулсан бол 1976 онд 200 ортойгоор “Аймгийн Нэгдсэн эмнэлэг”, 2021 оноос одоог хүртэл 422 ортойгоор “Аймгийн Нэгдсэн эмнэлэг” гэж өргөжин эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлсээр байна. Нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж нь дараах зохион байгуулалттай. Үүнд:

- А корпус буюу НЭ-ийн төв хэсэг- Нийт тасаг нэгжийн 80% нь байрладаг.
- В корпус буюу НЭ-ийн төрөх эмнэлэг- Төрөх-эмэгтэйчүүд, нярайн хэсэг, ЦСТөв, эмгэг судлалын тасаг, гемодиализ, сэтгэцийн эмгэг судлалын тасаг, халдвартын тасаг байрлана.
- С корпус буюу НЭ-ийн хүүхдийн эмнэлэг-Хүүхдийн тасаг, хавдар-хөнгөвчлөхийн тасаг, арьс судлалын тасаг, уламжлалт-сэргээн засахын өдрийн эмчилгээ тус тус байрлана.

- Д корпус буюу НЭ-ийн уламжлалт- сэргээн засахын хэвтэн эмчлүүлэх тасаг байрлана.

.12 Нэгдсэн эмнэлэг нь дараах бүтцээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- Удирдлага -3
- Амбулатори – 23 тасаг, нэгж/ кабинет/
- Стационарын – 17 тасаг
- .Паракилиник - / Лаборатори Б. Дүрс оношилгоо
- Дэмжих төв
- 7 алба: -ЭМТҮЧАБ алба
 - Хүний нөөц, сургалтын алба
 - ХСХ-ын алба
 - Сувилахуйн алба
 - Санхүүгийн алба
 - ЭЗДСМТ-ийн алба/эдийнзасаг,даатгал,статистик,мэдээлэл технологи/
 - ИТ-ийн алба/инженер техник/

1.3 НЭ-ийн хүний нөөцийн хангалтыг сүүлийн 5 жилээр авч үзвэл:

№	Хүний нөөцийн хангалт				
Он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Үзүүлэлт	444	461	470	470	495

1.4 Хүний нөөцийн хангалтыг сүүлийн 2 жилээр мэргэжил тус бүрээр судлан үзвэл:

2022 онд:

- 1.Удирдах ажилтан-3
- 2.Их эмч -111
- 3.Сувилагч, тусгай мэргэжилтэн-218
- 4.Биа-анагаах мэргэжилтэн-4
- 5.Бусад-134

2023 онд:

1. Удирдах ажилтан-3
2. Их эмч -119
- 3.Сувилагч, тусгай мэргэжилтэн-229
- 4.Биа-анагаах мэргэжилтэн-4
- 5.Бусад-140

1.5 Нийт мэргэшлийн зэрэгтэй 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй. Үүнээс:

- Тэргүүлэх зэрэгтэй их эмч-3
- Тэргүүлэх зэрэгтэй сувилагч-21
- Клиникийн профессор-10
- Магистрийн зэрэгтэй-8

- Тэргүүлэх зэрэгтэй эх баригч-1
- Ахлах зэрэгтэй их эмч-18
- Ахлах зэрэгтэй сувилагч-30
- Ахлах зэрэгтэй эх баригч-3
- Зөвлөх зэрэгтэй сувилагч-1

1.6 Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээг хүснэгтээр харуулвал:
ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

/MNS5095:2017/

№	МЭРГЭШИЛ	Нарийн мэргэшлийн их эмч		НИЙТ
		АМБУЛАТОРИ	ТАСАГ	
1	Дотор	3	9	12
2	Мэдрэл	2	2	4
3	Хүүхэд	1	5	6
4	Мэс засал	1	5	6
5	Гэмтэл согог судлал	2	2	4
6	Эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүй	1 /асуух/	11	12
7	Сүрьеэ	1	2	3
8	Нүүр ам судлал	1	5	6
9	Насжилт, настны эмгэг судлал	1	0	1
10	Өсвөр үеийн эрүүл мэнд	0	1	0
11	Сэтгэц	1	2	3
12	Арьс, харшил	1	1	2
13	Нүд судлал	1	1	2
14	Чих, хамар хоолой	1	1	2
15	Хавдар	1	1	2
16	Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг	0	6	6
17	Уламжлалт анагаах ухаан	0	4	4
18	Яаралтай тусламж	0	4	4
19	Эмгэг/эс судлал	1	1	2
20	Түргэн тусламж	4	0	4
21	Цусны салбар төв	0	1	1
22	Зүрх кардиологи	1	1	2
23	Халдварт	1	1	2
24	Дүрс оношилгоо	2	2	4
25	Дуран эндоскоп	1	0	1
26	Гемодиализ	0	1	1
27	БЗДХ	1	0	1
Нийт тоо 97				

Тайлбар: / Лаборатори, халдвар судлаач эмч, эм зүйн албыг оролцуулаагүй болно/

”Баян-Өлгий аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр 2017-2021 он”-ыг мөрдөн хэрэгжүүлсэн ба ЭМС-ын 2022 оны А/609 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” батлагдан гарсантай холбогдуулан Нэгдсэн эмнэлгийн стратеги төлөвлөгөөг ахин шинэчлэн боловсруулах шаардлага гарсан.

2.Үндэслэл

Монгол Улсын урт хугацааны бодлогын бичиг баримт “Алсын хараа-2050”, Аймгийн ЗД-ын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрийг тус тус үндэслэн боловсруулсан ба Стратеги төлөвлөгөөг ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор батласан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийн хангах журам болон төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан.

2.1 Хууль тогтоомжийн орчин

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу салбарын чиг үүргийн мандатыг 2022 онд хийсэн.Дүн шинжилгээ хийдээ Нэгдсэн эмнэлгийн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд

2.1 Нэгдсэн эмнэлгийн хэвтэн эмчлүүлэгчийн тоо /сүүлийн 5 жил/

№	Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн тоо				
1	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
2	11882	12858	12341	12341	16322

2.2 Нэгдсэн эмнэлэгт амаржсан эхийн тоо

№	Төрсөн эхийн тоо				
1	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
2	2387	2430	2385	2472	2432

2.3 Сүүлийн 5 жилээр амбулаторын үзлэгийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Амбулаторийн үзлэгийн тоо	102099	99964	98706	166687	141922
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	23835	22727	23080	36793	18087

2.3 Мэс заслын тоо/сүүлийн 5 жилээр/

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Нийт мэс заслын тоо	1792	1479	1845	2220	2100
2	Кесарев мэс засал	546	556	605	681	628

2.5 0-5 насны хүүхдийн эндэгдлийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	0-5 насны хүүхдийн эндэгдэл	27	36	29	40	20
2	0-1 насны хүүхдийн эндэгдэл	22	32	25	36	16
3	1-5 насны хүүхдийн эндэгдэл	5	4	4	4	4

2.6 Эхийн эндэгдлийн үзүүлэлт/ сүүлийн 5 жил/

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Амьгүй төрөлтийн тоо	16	11	13	17	10
2	Эхийн эндэгдэл	0	0	4	1	2

2.7 Орны фонд ашиглалт ба орны тоо

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Орны фонд ашиглалт	254,7	276,9	252,1	256,9	263,2
2	Орны тоо	319	319	319	422	422
3	Дундаж ор хоног	6,8	6,9	6,5	7	6,8

2.6 Нэгдсэн эмнэлгийн хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд

№	Тэргүүлэх шалтгаан	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Амьсгалын тогтолцооны өвчлөл	1067.03	1162.14	802.72	615.32	1449.0
2	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	902.24	1932.14	2074.93	2266.27	2090.9
3	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	806.21	1153.95	1008.1	978.77	1096.9
4	Зүрх судасны тогтолцооны өвчин	883.34	1075.83	1108.31	973.35	1334.4
5	Мэдрэлийн тогтолцооны өвчин	140.63	230.69	598.87	619.4	766.7

2.7 Нэгдсэн эмнэлгийн нас баралт

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Эмнэлгийн нас баралт	72	71	65	79	36
2	Хоног болоогүй нас баралт	8	12	7	18	12

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

№	ТҮВШИН	АЛСЫН ХАРАА
1	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ	Дэлхийн жишигт хүрсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрт
2	БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ давамгайлсан эмнэлгийн байгууллагуудын хүчин чадлыг бэхжүүлэн, улсын стандартын түвшинд хүргэж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанар үр дүнг сайжруулан хүн амын өвчлөлийг

		бууруулж, дундаж наслалтыг уртасгахад оршино.
3	БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ	JCI нэвтрүүлсэн анхдагч эмнэлэг болно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

№	ТҮВШИН	ЭРХЭМ ЗОРИЛГО
1	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ	Эрүүл дадал хэвшилтэй, идэвхитэй, амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үрдүнтэй тогтолцоог хөгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж монгол хүний эрүүл дундаж наслалтыг уртасган 2024 онд 73-д хүргэнэ.
2	БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР	Үйлчүүлэгчдийн эрхийг дээдэлсэн үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн үйлчилгээг эрхэмлэнэ.
3	БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ	Баруун бүсийг тэргүүлсэн олон улсын стандартад нийцсэн шилдэг, чанартай, нотолгоонд суурилсан аюулгүй, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлсэн, үйлчилгээг үзүүлдэг чадварлаг багаас бүрдсэн оношлогоо эмчилгээний Нэгдсэн эмнэлэг болно.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Нэг. Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
1.Бүтэц, зохион байгуулалт	
MNS 5095:2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажилагааны стандартад заасан бүтэц, зохион байгуулалттай.	2021 оноос одоог хүртэл 422 ортойгоор “Аймгийн Нэгдсэн эмнэлэг” гэж өргөжин эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлсээр байна. Нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж нь дараах зохион байгуулалттай. Үүнд: • А корпус буюу НЭ-ийн төв хэсэг- Нийт тасаг нэгжийн 80% нь байрладаг. • В корпус буюу НЭ-ийн төрөх эмнэлэг- Төрөх-эмэгтэйчүүд, нярайн хэсэг, ЦСТөв, эмгэг судлалын тасаг, гемодиализ, сэтгэцийн эмгэг судлалын

	тасаг, халдвартын тасаг байрлана. - С корпус буюу НЭ-ийн хүүхдийн эмнэлэг-Хүүхдийн тасаг, хавдар-хөнгөвчлөхийн тасаг, арьс судлалын тасаг,уламжлалт- сэргээн засахын өдрийн эмчилгээ тус тус байрлана. - Д корпус буюу НЭ-ийн уламжлалт- сэргээн засахын хэвтэн эмчлүүлэх тасаг байрлана. Эмнэлгийн тусламж үйлчилгээ өргөжин тэлэгдэхийн хирээр хуучин барилга байгууламжийн стандарт орчин цагийн барилга байгууламжийн стандартыг хангахгүй байгаагаас үүдэн стандарт шаардлага хангасан шинэ эмнэлгийн барилга байгуулах хэрэгцээ үүссэн. 17,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий шинээр баригдаж буй эмнэлгийн шинэ барилга нь: - Хэвтэн эмчлүүлэх хэсэг - Амбулатори - Эмгэг судлалын хэсэг гэсэн 3 том корпус тайгаар зохион байгуулагдсан.Одоогоор шинэ барилгын ажлын гүйцэтгэл нь 50%-тай байна.
2. Хүний нөөц	
MNS 5095:2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажилагааны стандартад заасан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр хангагдсан	1.MNS 5095:2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажилагааны стандартад заасан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр хангагдсан боловч хүн амын эрчимтэй өсөлт, 1 эмч болон 1 сувилагчид ноогдох үйлчлүүлэгчийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор эмч болон сувилагчийн хүрэлцээ хомс байна. 2.Өндөр өртөгт тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах мэргэжилний нөөц хомс.Одоогоор тус аппаратуудыг ажиллуулах мэргэшсэн мэргэжилтэн сургагдаагүй. 3. Мэргэшсэн эмч, мэргэжилтэн сургагдаагүй. 4.Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, ажиллагсдын ёсзүйн хандлагын төлөвшил жигд бус байгаа нь

	үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид нөлөөлдөг. 5.Нөгөө талаас үйлчлүүлэгчийн эмчтэй харилцах харилцаа муу, заавал үйлчлүүлэгч би-ХААН гэсэн төлөвшөөгүй зан харьцаа нь эмч, мэргэжилтнүүдийг дорд үзэх үзэл зэрэг нь тусламж үйлчилгээнд төвөгтэй байдал үүсгэж байна.
3.Салбарын санхүүжилт	
ЭМДҮЗ-ийн 8-р тогтоолоор зохицуулагдан санхүүжиж байна.	ЭМДҮЗ-ийн тогтоолоор зохицуулагдаж байгаа боловч • Оношийн кодын хасагдал • Их олонлогийн хасагдал • ЭМД-ын ил тод байдал харилцан мэдээлэл солилцох байдлын хяналтын процессын байдал, • Мэдээлийн хоцрогдол,алдаа дутагдал хасагдлын зөвлөмжийг цаг тухайд нь өгдөггүй, дараагийн нэхэмжлэлээс өмнө өгдөггүй гэх сул талтай байна. • Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөлийн эрүүлжүүлэлт хангалтгүй.
4.Тоног төхөөрөмжийн хангалт	
Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт-89%-тай байна:	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээ тэлэгдэн, хүртээмж, чанар сайжирч, оношлогоо, шинжилгээний орчин цагийн аппаратаар хангагдаж байгаа боловч орон нутгийн хэмжээнд өндөр өртөгт оношлогоо шинжилгээний аппаратын хангалт дутмаг байна.Үүнд: • MRI- аппарат/ 1тэрбум ₮ өртөгтэй/ • VITEK аппарат/бактериологи хийх /200 сая ₮ өртөгтэй/ • Ангиографи хийх аппарат, тоног төхөөрөмж 1тэрбум ₮ өртөгтэй/
4.Мэдээллийн технологи	
Е.HEALTH программаар цахим өвчтний түүхийн бичилт хийгдэж хэвшсэн. Интернет цахим сүлжээтэй, ихэнх үйл ажиллагаа цахимжсан.	1.Тус программаар цахим өвчтний түүхийг хянаж байгаа боловч эмч, эмнэлгийн мэргэжилтний цахим өвчтний түүхийн бичилт заримдаа шаардлага хангахгүй байна.

	2. Интернет цахим сүлжээний хурд сул зэрэг нь цахим түүх бичилтэд шууд нөлөөлж байна. 3.Эмч, эмнэлгийн мэргэжилтний ачаалал нь цахим түүх бичих явцад үйлчлүүлэгчийн өдөр тутмын бичилтийг шууд хуулан бичин үйлчлүүлэгчийн өдөр тутмын үзлэгийн динамик өөрчлөлт шууд тусгагдан гарахгүй байна.
5.Салбарын засаглал, ил тод байдал	
Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, ажилчдын ажлын гүйцэтгэлийг тогтмол үнэлэн улирлаар урамшуулал олгож хэвшсэн.	• Засгийн газрын 2019 оны 5-р тогтоолын Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл мөнгөн урамшуулал олгох журмын 3-р хавсралт • Засгийн газрын 2019 оны 395 дугаар тогтоол • Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 30 дугаар зүйлийн 30.5 дахь заалтыг үндэслэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, ажилчдын ажлын гүйцэтгэлийг тогтмол үнэлэн урамшуулал олгож хэвшсэн ч урамшуулал олголтыг цаашид улам сайжруулан ажлын гүйцэтгэлээр KPI үнэлгээгээр хийхээр төлөвлөсөн байна.
Хоёр. Гадаад орчин	
Боломж	Эрсдэл
АЗД-ын 2021- 2024 оны мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн тулгамдсан асуудлын шийдвэрлэх заалтууд тусгагдсан. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль батлагдснаар эмнэлгийн засаглал зах зээлийн зарчмаар хөгжих боломж бүрдсэн. Шилэн дансны хууль хэрэгжиж, төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал сайжирсан.	Эрүүл мэндийн салбарын удирдах мэргэшсэн ажилтны нөөцийн хомс үүсэх эрсдэлтэй. Эрүүл мэндийн газрын удирдах ажилтны манлайлал харилцан адилгүй. Эмч мэргэжилтнүүдийн гадаад сургалт хангалтгүй. Эмч, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эрхзүйн орчин бүрдээгүй. Эмзэг бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй.


ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний чадавхыг бэхжүүлэн гүйцэтгэлийн санхүүжилт , цахим мэдээллийн тогтолцоог бүрэн нэвтүүлсэн, төрөлжсөн нарийн

мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүн амыг эрүүлжүүлэхэд оршино.

ДОЛОО.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ба ТАСАГ НЭГЖИЙН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

2022 оны жилийн эцсийн байдлаар Нэгдсэн эмнэлгийн хэмжээнд дараах бүтцээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг.Үүнд:



НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ болон ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

№	Үзүүлэлт	Суурь түвшин 2022 он	Хүрэх түвшин		
			2023 он	2024 он	2025 он
1.	Жирэмсний эхний 3 сартайд	92,3	93	94	95

	хяналтад орсон эхийн эзлэх хувь				
2.	Эхийн эндэгдлийн түвшин /100000 амьд төрөлт тутамд/	81,6	72,2	50	30
3.	Нялхасын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/	6,5	6,0	5,9	5,8
4.	Нярайн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/	6,1			
5.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /100000 амьд төрөлт тутамд/	1,6	1,5	1,5	1,4
6.	Амьгүй төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд	4,1	4,0	3,9	3,8
7.	Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	9,9	15	20	25
8.	Эрхтэн тогтолцооны эмгэгийн диспансерийн хяналтын идэвхтэй хяналтын тоо, хувь	12,1	13	14	15
9.	Эмгэг судлалын задлан шинжилгээний хувь	56,8	56,8	58	60
10.	Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт	6,1	7	8	9
11.	Үндсэн оношийн зөрүү	13,0	12,5	12,0	11,0

3. Хүүхдийн сэргээн засах тусламж үйлчилгээ дутмаг / Багаж, тоног төхөөрөмж
4. Ангиографийн оношилгоо эмчилгээний иж бүрэн аппарат
5. Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт

Анхны үзүү 3 мян-ын гурван туслах.

ХЯНАСАН

ЭМНЭЛГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЕРЖАН



БИЧСЭН

ЭМТҮЧАБА-НЫ ДАРГА

Д.ГҮЛЖАН

(Signature of D. Guljan)

*Бүтэн, хүн-ийн нэгдсэн нэгдсэн
үндэслэлтэй туслах.*